

СОНИН

ЭРЭЛ, ТААМНАЛ

«АЛТАН ХҮН» ЮУ

ХҮҮРНЭНЭ ВЭ?

Цаглашгүй санааны галбираасан мод үндэсний хүчинд газрын шимээр ундаалан мөчир салаа нэмдэг лугаа нэгэн адил хүмүүн төрөлхтний яндашгүй соёл өмнөх үеийнхээ өв уламжлалаас эх ундарга авсаар улам баяжиж, урагшлан хөгждөг байнам. Археологич, эртний хэл шинжлэлтэн мэргэд мөхөж үрэгдсэн эртний соёл иргэншлийн мөр улбааг мөшгөн хөөж, мартагдаж орхигдсон үсэг бичгийнх нь нууцыг тодруулах гэж цаг хүчээ сүйтгэн байдаг нь түүн лүгээ холбоотой буй заа. Германы Шлиман Гомерийн алдарт «Илионы дуулалд» гардаг эртний Трой хотыг олсон, францын Шампольон Розетийн чулууны бичгийг уншин, мисирийн дүрс бичгийн нууцыг тайлсан, английн Роулинсон Бехистуны хадны бичээсийг уншиж, перс, вавилоны шаантаг бичгийн оньсыг таасан, данийн Томсен Орхон, Енисейн рун бичгийн түлхүүрийг олсон зэрэг нь хүн төрөлхтний соёлын түүхнээ гайхамшигт нээлт болон оржээ. Кавказын агван бичиг, Критын фестийн хүрдийн бичиг, Пасха арлын «ярьдаг мод», Перугийн Наске цөлийн «зураг» нууцаа тайлах эзнээ хүлээсээр байна.

Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг дахь эртний нэгэн булшнаас олдсон «алтан хүн» дэлхийн соёлын эрдэнэсийн сангийн тэдгээр хосгүй дурсгалтай эн зэрэгцэнэ. Археологч Д. Наваан, хэл шинжлэлтэн Б. Сумьяабаатар нар «Өвөг монгол хэл, бичгийн чухаг дурсгал» гэсэн судалгааныхаа номыг тэрхүү «алтан хүний» нууцыг тайлахад зориулжээ. Үр сад бидэндээ уламжлуулан үлдээсэн соёлын ийм дурсгалаар нь урьд үеийнхээ хүмүүсийн үүх түүх, аж төрөл бүтээл туурвил, бодол тэмүүллийг олж мэдэх, ингэснээр өөрсдийгөө таних, улмаар урагш замнах нь өнөөгийн бидний эрхэм үүрэг. Овгоо мэдэхгүй хүн ойд төөрсөн сармагчинтай адил гэж ухаан төгс өвөг дээдэс маань бидэндээ аминчлан захисны учир тэр буюу. Үүнийг үл өгүүлэн өгүүлэхэд, тэрхүү булш ямар он цагт, ямар улс гүрэнд хамаарах вэ, язгууртан, элч, харц ямар хүнийх вэ, булшнаас гарсан «алтан хүн» юунд зориулагдаж байсан бэ, хэний хөрөг вэ, дээрх тэмдгүүд нь ямар бичгийн дурсгалд холбогдолтой, ямар хэлээр бичигдсэн, юу гэсэн утгатай вэ гэх зэрэг «олон үл мэдэгдэгчтэй тэгшитгэлийн» хариуг гаргах адар-

Д. Наваан булшнаас гарсан зүйлийг монгол нутгаас археологийн малтлагаар олдсон хүннү нарын эд өлгийн зүйлстэй харьцуулан судлаад, уг булшийг ч, «алтан хүнийг» ч хүннү нарын үед хамаарна гэсэн дүгнэлт хийсэн байна. Б. Сумьяабаатар археологчийнхоо дүгнэлтийг ихэд баяжуулжээ. Түүний судалгаа хэл бичгийн гэгдэж байгаа боловч түүх, археолог, урлаг, угсаатны зүйтэй холбогдсон цогц судалгаа болжээ гэж хэлж болно. Сумьяабаатар булшнаас гарсан эд өлөг, үхэгсдээ оршуулдаг байсан эртний ёс, түүхэн сурвалж бичгийн баримт сэлт зэргээс ургуулан, уул булшийг хятан улсын үеийнх, шарилыг нь хятаны Тянь-цзо хааных гэж дүгнэсэн байна. Харин булшны хамгийн нандин олдвор «Алтан хүнийг» монголын дээд өвөг хүннү нартай холбоотой гэж археологчийн дүгнэлтийг бататгаад, тэгэхдээ бүр хүннүгийн их хаан Моодон шаньюйн эцэг Түмэн шаньюйн хөрөг байна, түүнээс монгол овогтны шүтээн болон уламжилж явсаар хятан нарыг хүрч ирсэн байна гэсэн таамнал дэвшүүлжээ. «Хүннүгийн Сютуд «алтан хүн» нэр шүтээн байсан» гэсэн сурвалж бичгийн тэмдэглэлээр судлагч санаагаа батлаад, тэр «алтан хүн» олдож байгаа юм биш биз гэсэн тун сонин санал хэлжээ. Тэр бүхний дотроос «Алтан хүний» толгойн хоёр талд гаргасан тэмдгүүд судлагчийн анхаарлыг татсан нь зүйн хэрэг мөн. Тэдгээр үсгийг дэлхийн бичгийн соёлын өргөн дэлгэр цар хүрээнд авч үзэж, Европ дахь Критын фестийн хүрдийн бичиг, Номхон далайн Пасха арлын кохау ронго ронгогийн тэмдэг, эртний дарвидын тамгын бичээс, солонгос авианы бичигтэй харьцуулжээ. Эдгээрээр үл хязгаарлаж финик, арамей бичгийг улируулан үзэж, салаа салбарыг нь мөшгин цөлбөж, этрус, орхон енисейн рун зэрэг арван таван цагаан толгойн үсгийн дүрс, дуудлагыг зэрэгцүүлэн шинжилсэн байна. Ийнхүү энэ судалгаандаа тулгуурлан уг бичээсийн утгыг хүннү хэлээр «Хааны тамга (тэмдэг)» гэж бичсэн байна гэж тайлжээ. Өөрөөр хэлбэл хүннү нарыг финицээс уламжлан авсан бичигтэй байжээ гэж сонирхолтой дүгнэлт хийжээ. Хүннү нар бичигтэй байсан нь эртний түүхийн сурвалж бичгүүдэд нэгэнт тэмдэглэгдсэн байдаг тул эрдэмтэд тэр талаар төдий л маргадаггүй боловч тэд чухамхүү ямар бичиг хэрэглэж байсан нь өнөөдрийг хүртэл таавар байлаа. Тэгвэл Сумьяабаатарын судалгаа энэ тааврыг тайлж, монголын соёлын түүхийн нэгэн «цагаан толбыг» арилгаж байгаа юм биш үү. Шинжлэх ухааны таамнал шинжлэх ухааны үнэн болж яддаггүй билээ. Уг бүтээлийг ихэд сонирхон уншсаны хувьд, монголынхоо соёлд хайртайн хувьд чухамхүү тийм болоосой гэж туйлаас хүснэм, Жинхэнэ шинжлэх ухааны үнэлэлт дүгнэлтийг бол түүхч, археологич, хэл шинжлэлтэн нар өгөх биз ээ. Ямар ч гэсэн хоёр мянган жилийн түүхтэй «алтан хүн» нууцаа задруулж эхэллээ. Монгол түмний маань гайхамшигт соёлтой байсныг гэрчлэн нотлох өөр ямар «алтан эрдэнэ» эх сайхан нутагт маань нуугдан байгаа бол?

Г. АКИМ